



GRATA
INTERNATIONAL

**ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ
ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**


ГРАТА Интернэшнл Монголиа

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ: гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн

Авах тухай эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад 2022 оны I улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 92 улсын 5463 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 1030 –аар буюу 23.2 хувиар нэмэгдсэн байна. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 4752 (87.0 хувь) нь эрэгтэйчүүд, 711 (13.0 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 36.6 хувь нь Улаанбаатар хотод, 5.8 хувь нь Баруун бүсэд, 5.3 хувь нь Хангайн бүсэд, 36.7 хувь нь Төвийн бүсэд, 15.6 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл:



Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад 5 шат дарааллаас бүрдэнэ. Үүнд:

1. Ажлын зөвшөөрлийн урьдчилсан зөвшөөрөл буюу урилга авах;
2. Визний зөвшөөрөл хүсэх;
3. Гадаадын ажиллах хүчин Монгол улсын хилээр орж ирэх;
4. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах;
5. Оршин суух зөвшөөрөл авах.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж угсрах, засварлах, төсөл хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн өндөр ур чадвар

шаардах ажил, мэргэжлээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээг гадаадын хуулийн этгээдтэй байгуулж болно.

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээнд дараах ерөнхий нөхцлийг тусгана¹:

- гадаадын иргэний ажиллах байгууллага, гүйцэтгэх ажил үүрэг;
- гадаадын иргэний ажиллах мэргэжлийн чиглэл, ажлын байрны нэр, хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний тоо;
- гадаадын иргэний эрүүл мэндэд тавих шаардлага;
- мэргэжил, боловсролын түвшинг баталсан баримт бичгийг харилцан зөвшөөрөх нөхцөл;
- гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох, түүнийг цуцлах нөхцөл;
- цалин хөлсний хэмжээ;
- хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цагийн горим;
- орон сууц, ахуйн хангамжийн асуудал;
- нийгмийн даатгалын асуудал;
- гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх маргаан болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх арга хэлбэрүүд.

Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар тогтоол гаргаж, хувийг нь тогтоодог.

Засгийн газраас тогтоосон гадаад иргэдийн харьцааг тооцохдоо Монгол ажилчдын төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхойлолтод үндэслэнэ. Ажилчдын тоог үнэн зөв, бодитой тогтоохын тулд тухайн дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс тодорхойлолт гаргуулна. Дээрх тодорхойлолтыг үндэслэн эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажиллаж буй гадаад иргэд, мэргэжилтнүүдийн харьцаа, Монгол Улсын нийт ажиллагсдын тоонд байгаа гадаадын иргэдийн харьцааг тооцож хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас олгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2022 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тухай 231 дугаартай тогтоолын дагуу Монгол Улсад 2022 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг нийт ажиллагчдын тоонд эзлэх хувиар хязгаарлахгүй байхаар тогтоосон.

2021 онд Засгийн газрын 2021 оны 123 дугаар тогтоолоор 5-20 монгол ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн салбар харгалзахгүйгээр 1 гадаад ажилтан ажиллуулах боломжтой байхаар тогтоосон. Тус тогтоол нь жил бүр шинэчлэгдэж гардаг тул 2023 онд гадаадаас авах боловсон хүчин, мэргэжилтний журамд зарим өөрчлөлт орж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

¹ <https://mlsp.gov.mn/content/detail/1054>

Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн удирдлагын багийн 3 хүртэл төлөөлөгч, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын 1 гадаадын хөрөнгө оруулагч энэ тогтоолд заасан хувь, хэмжээнээс үл хамааран хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл шаардахгүйгээр ажиллах боломжтой.

Гадаадын иргэн Монгол Улсад ажиллах зөвшөөрлийн хугацаа 1 жил хүртэл байх ба тухайн байгууллагын хүсэлт, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үр дүн, цаашид ажилд орох болсон шалтгаан зэргийг харгалзан зөвшөөрлийн хугацааг сунгаж болно. Гадаадын иргэнд олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг тухайн байгууллагын бичгээр хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тооцно.

Визгүй зорчих паспорттой иргэн 30 хоног зорчих эрхтэй тул ирэхээсээ өмнө ажлын урилга авах шаардлагатай.

Ажлын зөвшөөрлийн урьдчилсан зөвшөөрөл буюу урилга

Эхний алхам нь аж ахуйн нэгж гадаад ажилтныг урьж, өргөдөл гаргагч эсвэл ажилтанд визний урилгын захидал илгээж, ажлын зөвшөөрлийг урьдчилан батлах явдал юм. Дараах бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай:

1. Өргөдлийн маягт;
2. Улсын тэмдэгтийн хураамж (нэг хүнд 25000 төгрөг ~ 7,9 ам. доллар);
3. ААНБ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралтын хуулбар;
5. Засгийн газрын тогтоолоор квотоос чөлөөлөгдсөн бол ЗГТ-ын хуулбар (шаардлагатай тохиолдолд). Гадаадын ажилтны квотыг Монгол Улсад ажиллаж буй дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдэд жил бүр Монгол Улсын Засгийн газраас тогтоодог;
6. Тухайн байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлдөг хэдэн ажилтантайг баталгаажуулсан нийгмийн даатгалын сүүлийн сарын НД-7 болон НД-8 маягт;
7. Хөдөлмөр эрхлэлтийн эдийн засгийн салбарын яам, агентлагийн тодорхойлолт;
8. Тухайн байгууллагын харьяалагдах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн санал;
9. Гадаадын хуулийн этгээдтэй хөдөлмөр эрхлүүлэх талаар байгуулсан Хөдөлмөрийн гэрээ, түүний монгол хэл дээрх орчуулгын хамт (орчуулгын товчоогоор баталгаажсан тэмдэгтэй);
10. Гадаадын иргэний паспортын хуулбар;
11. Гадаадын иргэний хөдөлмөр эрхлүүлэх салбарт их, дээд сургууль төгссөнийг илтгэн харуулах мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар (орчуулгын товчоогоор баталгаажсан тэмдэгтэй);
12. Шаардлагатай бол бусад материал.

Гадаадын иргэд Монголд ирэхээс нэг сарын өмнө урьдчилсан зөвшөөрөл авах хүсэлтээ гаргасан байх ёстой. Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын арав хоногийн дотор шийдвэрлэнэ.

Визний зөвшөөрөл хүсэх

“Монгол Улсын виз” гэж эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын хилээр нэвтрэх, Монгол Улсад тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг хэлнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэн Монгол Улсын виз зохих журмын дагуу авсан байна. Визийг хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичигтэй гадаадын иргэнд олгоно.

Гадаадын иргэн Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газартай улсаас ирж байгаа тохиолдолд тухайн дипломат төлөөлөгчийн газарт, Элчин сайдын яам, консулын газаргүй улсаас ирж байгаа тохиолдолд хилийн боомт дээр визийг олгуулахаар визийн зөвшөөрөл хүснэ.

Монгол Улсад 91 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэн нь албан болон хувийн хэргээр оршин суух визийн зөвшөөрөл хүсэх боломжтой бөгөөд дипломат, албан, хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч, суралцагч, гэр бүлийн зорилгоор, хувийн зорилгоор, шашны зорилгоор, цагаачлах гэсэн чиглэлүүдээр виз авах боломжтой.

Хөрөнгө оруулагчийн виз нь дараах ангилалуудтай:

- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч (B1) ба тус хөрөнгө оруулагчийн хамаарал бүхий этгээд (B1-1) ;
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэн (B2) ба тус хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (B2-1);
- Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэн (B3) ба тус гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (B3-1);

Хөдөлмөр эрхлэгчийн виз нь дараах ангилалуудтай²:

- Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C1) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C1-1);
- Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбар ажиллахаар ирэх гадаадын иргэн (C2) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C2-1);
- Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C3) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C3-1);
- Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C4) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C4-1);
- Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C5) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C5-1);
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C6) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C6-1);
- Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C7) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C7-1);
- Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C8) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C8-1);

² <https://immigration.gov.mn/mn/visa-total/visa-type/>

- Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн (C9) ба тус гадаадын иргэний хамаарал бүхий этгээд (C9-1);
- Өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр ажиллахаар ирэх гадаадын иргэн (C10);
- Тээврийн салбарт ажиллах болон экспортын ачаа тээвэрлэх гадаадын иргэн (C11).

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл

ААНБ нь гадаадаас хөдөлмөр эрхлэгч ангиллын визээр урьж ирүүлсэн ажиллах хүч, мэргэжилтнээ Монгол Улсын хилээр орж ирснээс хойш ажлын 10 хоногийн дотор бүртгүүлж, дараах бичиг баримтын хамт хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авна.

1. "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсэх" Маягт-2-ыг дэлгэрэнгүй бөглөсөн албан бичиг;
2. Улсын тэмдэгтийн хураамж (нэг хүнд 22500 төгрөг ~ 7.1 ам.доллар);
3. Ажлын байрны төлбөр төлсөн баримт (нэг хүнд сард 840000 төгрөг ~ 263,9 ам.доллар) /баримт бичгийг эрх бүхий байгууллагаас шалгуулж төлсөн байх/;
4. ААНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
5. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралтын хуулбар;
6. Засгийн газрын тогтоолоор квотоос чөлөөлөгдсөн бол ЗГТ-ын хуулбар;
7. Гадаадын иргэний паспортын хилээр орж ирсэн штамп дарагдсан хуудасны хамт
8. Эрүүл мэндийн болон Хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан маягтын дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан дүгнэлт бичиг (Тавигдах шаардлага: хөдөлмөр эрхлүүлэх газрын харьяалах эрүүл мэндийн төвд гадаадын ажиллах хүч, мэргэжилтнүүдийг авч очин ЭМУШ-нд хамруулж, эмч, ерөнхий эмчийн гарын үсэг тайлал, огноо, дүгнэлтийг гаргацтай бичүүлж, тэмдэг дарж баталгаажуулсан байна).

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох нь ажлын 3-5 хоног үргэлжилнэ. Ажиллах зөвшөөрлийг нэг (1) жил хүртэл хугацаагаар олгоно.

Ажлын байрны төлбөр

Ажлын байрны төлбөр гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө хуулиар ногдуулсан төлбөрийг ойлгоно.

Гадаадын иргэнд сар бүр ногдуулах ажлын байрны төлбөрийн хэмжээ нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. 2022 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420000 төгрөг байна.

Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөх, чөлөөлөх журам"-д заасан холбогдох материалыг бүрдүүлэн аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ. Авто зам, төмөр зам гэх мэт стратегийн дэд бүтцийн төслүүдэд энэхүү хөнгөлөлтийг олгодог.

Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг 2015 оны Засгийн газрын тогтоолын хавсралт болох Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмаар зохицуулсан. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч, гишүүн, удирдах бүрэлдэхүүний 3 хүртэлх төлөөлөгчийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

Үүнээс гадна дор дурдсан гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө:

- Монгол Улсад суугаа гадаад орны дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтан, түүний гэр бүл;
- Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар (НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын салбар гэх мэт)-т ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүл;
- Боловсролын байгууллага, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх, мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан;
- Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжилтэн, ажилтан;
- Монгол Улсын олон улсын гэрээ болон төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу ажиллаж байгаа сайн дурын ажилтан;
- Хууль ёсны зөвшөөрөл авч Монгол Улсад хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын төрийн бус (ашгийн бус) байгууллагын ажилтан.

Гадаадын ажилтан, мэргэжилтнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөхөд Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газар, яам, Засгийн газрын агентлагийн байгуулсан гэрээ, тухайн иргэний мэргэжлийн диплом, үнэмлэх, байгууллагын хүсэлтийг тус тус үндэслэнэ.

Оршин суух зөвшөөрөл

Энэхүү зөвшөөрлийг доорх материалуудыг бүрдүүлэн Гадаадын Иргэн, Харьяатын газраас (ГИХГ гэх) авна. Монгол Улсад орж ирсэн өдрөөс 21 хоногийн дотор мэдүүлнэ. Монгол Улсад анх удаа оршин суух зөвшөөрөл хүсэж буй гадаадын иргэн өөрийн биеэр ГИХГ-т ирж, биеийн давхцахгүй өгөгдлийг /хурууны хээ, зураг/ бүртгүүлэх шаардлагатай. Албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан гадаадын иргэнийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхийг шаардана.

Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт (хөдөлмөр эрхлэгчийн төрөл):

- Уригч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт (Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх шаардлага, хугацаа зэргийг дэлгэрэнгүй дурдах);
- Визийн зөвшөөрөл мэдүүлэх үед гаргасан албан хүсэлтийн эх хувь, бүрдүүлсэн бусад баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
- Паспорт болон паспортыг орлох баримт бичгийн эх хувийг, хуулбарын хамт (паспортын хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх);
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас олгосон зөвшөөрөл;

- Баг, хорооны засаг даргаас авсан оршин суугаа хаягийн тодорхойлолт;
- Шаардлагатай бусад баримт бичиг;
- Тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- Мэдүүлгийн хуудас;
- Хүсэлт гаргаж буй ажилтанд тухайн байгууллагаас олгосон итгэмжлэх, ажлын газрын үнэмлэх, иргэний үнэмлэхний хуулбар.

Хүсэлтийг гадаадын иргэн эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч биечлэн мэдүүлнэ. Оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд 90 хоногийн дараа дахин хүсэлт гаргаж болно.

Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт (хөрөнгө оруулагчийн төрөл):

- Уригч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт (Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гадаадын иргэний Монгол Улсад байх зорилго, хугацаа зэргийг дэлгэрэнгүй дурдах);
- Визийн зөвшөөрөл мэдүүлэхэд гаргасан албан хүсэлтийн эх хувь, бүрдүүлсэн бусад баримт бичгийн хуулбарыг авч ирнэ.
- Баг, хорооны засаг даргаас авсан оршин суугаа хаягийн тодорхойлолт;
- Паспорт эсхүл паспортыг орлох баримт бичгийн эх хувийг, хуулбарын хамт (паспортын хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байна);
- Шаардлагатай бусад баримт бичиг (татварын болон нийгмийн даатгалын тодорхойлолт- тухайн жилийг оруулаад сүүлийн 3 жил г.м.)
- Хүсэлт гаргаж буй ажилтанд тухайн байгууллагаас олгосон итгэмжлэх, ажлын газрын үнэмлэх, иргэний үнэмлэхний хуулбар;
- Тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- Мэдүүлгийн хуудас.

Оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилээр олгоно.

2022 оны I улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 90 гаруй улсын 5463 иргэн Монголд ажил, хөдөлмөр эрхэлж байна. Ийнхүү гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад анхаарах зүйлс нь жил бүр гаргадаг Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоосон Засгийн газрын тогтоол, хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрөл буюу урилга, визний зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ажлын байрны төлбөр ба тус төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцлүүд болон оршин суух зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтууд болно.

Эх сурвалж:

1. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (2021)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390388880621/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390388880621/)
2. Монгол улсын ВИЗ олгох журам (2021)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721365191&showType=1/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721365191&showType=1/)
3. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам (2021)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721400211&showType=1/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721400211&showType=1/)
4. Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам (2015)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=206796&showType=1/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=206796&showType=1/)
5. Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам (2015)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=206652&showType=1/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=206652&showType=1/)
6. Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хавсралт (2021)
[/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084392271/](https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084392271/)
7. Үндэсний статистикийн хороо [/www.1212.mn/](http://www.1212.mn/);
8. Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам [/https://mlsp.gov.mn/content/detail/1054/](https://mlsp.gov.mn/content/detail/1054/);
9. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар [/https://avah.hudulmur-halamj.gov.mn/#/category/4/](https://avah.hudulmur-halamj.gov.mn/#/category/4/);
10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, [/https://avah.hudulmur-halamj.gov.mn/#/category/5/](https://avah.hudulmur-halamj.gov.mn/#/category/5/)

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон эрх зүйч Т.Буянжаргалтай bvolodya@gratanet.com, btungalag@gratanet.com эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм ГРАТА Интернэшнлийн Монгол дахь оффис болох Өмгөөллийн “ГРАТА Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэж байна. Энэхүү хууль зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудлаар нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Уншигч та аливаа үйлдэл хийх (эс хийх) –ээс өмнө өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.